



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК

Захирал Г.Саранчимэг

Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Аудитор: О.Мандах

Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/33
танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЭРДЭНЭМАНДАЛ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.ОНОНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөр арга хэмжээний зардалд 3,505,476.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 3,245,398.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансанд 255,965.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020265

2023 оны байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын хэмжээнд 3-р түвшинд үнэлэгдэн 43,000.0 мянган төгрөгөөр шагнагдсан, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 54 багш шалгагдан 31 багш 2, 3 дугаар түвшинд шалгарч 10-25 хувийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.9 хувьтай тайлагнасныг дээд шатны байгууллагаас 93.4 хувиар үнэлсэн байна. Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй,

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/ Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	360,103,232.72	480,733,876.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	64,535,446.19	255,965,794.38
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	64,535,446.19	255,965,794.38
31210	Төгрөг	64,535,446.19	255,965,794.38
31211	Төрийн сангийн харилцах	64,535,446.19	255,965,794.38
35	БАРАА МАТЕРИАЛ	295,567,786.53	224,768,082.21
35100	Түүхий эд материал	85,782,306.81	86,495,448.71
35110	Тусгай зориулалттай материал	75,259,756.81	83,074,948.71
35130	Эм боох материал	10,522,550.00	3,420,500.00
35400	Хангамжийн материал	209,785,479.72	138,272,633.50
35410	Бичиг хэргийн материал	8,904,453.00	1,523,500.00
35420	Аж ахуйн материал	8,044,602.00	8,131,257.00
35450	Барилгын засварын материал	21,195,730.00	13,630,445.00
35470	Бусад хангамжийн материал	171,640,694.72	114,987,431.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,189,485,091.38	5,333,340,697.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,189,485,091.38	5,333,340,697.31
39200	Биет хөрөнгө	3,543,710,091.38	4,687,125,697.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,614,856,157.36	4,935,161,872.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-533,593,545.20	-690,717,712.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	490,144,333.22	505,653,538.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-228,969,303.44	-238,184,909.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	304,570,818.05	306,346,496.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-182,278,529.61	-210,113,748.57
39217	Ном	78,980,161.00	78,980,161.00
39300	Биет бус хөрөнгө	645,775,000.00	646,215,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	646,325,000.00	646,765,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,549,588,324.10	5,814,074,573.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,549,588,324.10	5,814,074,573.90
51	Засгийн газрын хувь оролцоо	4,549,588,324.10	5,814,074,573.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,468,610,681.55	1,468,610,681.55
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,468,610,681.55	1,468,610,681.55
51200	Хуримтлагдсан үр дүн	1,046,207,998.50	2,310,694,248.30
51210	Өмнөх үеийн үр дүн	-3,497,040,917.60	1,046,207,998.50
51220	Тайлант үеийн үр дүн	4,543,248,916.10	1,264,486,249.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,034,769,644.05	2,034,769,644.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,549,588,324.10	5,814,074,573.90



Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,251,823,494.06	4,772,635,423.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	442,572,034.06	1,388,678,623.40
120	Нийтлэг татварын бус орлого	5,543,300.00	1,388,678,623.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,543,300.00	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,543,300.00	0
120009	Бусад орлого	490,000.00	56,935,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	398,186,114.50	1,320,305,715.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	38,352,619.56	11,437,608.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,809,251,460.00	3,383,956,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,112,740,200.00	2,847,773,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,112,740,200.00	2,847,773,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,471,460.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,471,460.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	565,039,800.00	536,183,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	565,039,800.00	536,183,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,957,156,816.44	3,508,149,173.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,957,156,816.44	3,508,149,173.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,696,872,298.51	3,367,061,933.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,623,886,231.60	2,003,243,982.28
210101	Үндсэн цалин	1,129,831,488.00	1,386,569,991.01
210102	Нэмэгдэл	397,544,971.60	545,949,349.27
210104	Урамшуулал	29,277,547.00	70,724,642.00
210105	Гэрээт ажлын хөлс	67,232,225.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,936,273.28	249,775,900.83
210201	Тэтгэврийн даатгал	139,634,964.31	172,033,719.90
210202	Тэтгэмжийн даатгал	16,406,115.91	19,824,982.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,956,571.61	15,580,626.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,990,554.99	3,939,466.99
210205	Эрүүл мэндийн даатгал	29,948,066.46	38,397,104.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	481,304,192.00	546,119,529.41
210301	Гэрэл, цахилгаан	19,729,738.00	28,343,998.35
210302	Түлш, халаалт	372,716,576.00	446,757,381.06
210303	Цэвэр, бохир ус	88,857,878.00	71,018,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,210,736.71	118,417,606.12
210401	Бичиг хэрэг	13,523,231.00	33,999,693.00
210402	Тээвэр, шатахуун	1,127,875.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,675,257.00	1,725,385.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,683,311.00	11,575,485.00
210408	Бараа материал акталсны зардал	0	70,017,042.72
210409	Бараа материал шилжүүлсний зардал	49,001,062.71	0
2105	Нормативт зардал	45,013,574.00	98,314,645.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,626,280.00	7,510,300.00

**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	41,387,294.00	90,804,345.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,055,800.00	33,790,115.00
210604	Урсгал засвар	18,055,800.00	33,790,115.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,317,600.00	17,060,772.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,671,600.00	6,905,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,646,000.00	10,155,472.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,147,890.92	300,339,382.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,148,397.00	29,606,473.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,550,907.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,448,586.92	270,732,909.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	260,284,517.93	141,087,240.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	258,074,932.00	137,023,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	124,301,864.00	108,487,450.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	127,471,460.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,301,608.00	28,536,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,209,585.93	4,063,690.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,209,585.93	4,063,690.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	294,666,677.62	1,264,486,249.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	294,666,677.62	1,264,486,249.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,815,284,760.00	3,440,892,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,033,300.00	56,935,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,033,300.00	56,935,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,543,300.00	56,935,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,543,300.00	41,022,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	15,912,900.00
120009	Бусад орлого	490,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,809,251,460.00	3,383,956,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,112,740,200.00	2,847,773,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,112,740,200.00	2,847,773,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,471,460.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	565,039,800.00	536,183,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	565,039,800.00	536,183,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,694,394,313.81	3,155,178,951.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,694,394,313.81	3,155,178,951.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,440,859,753.88	3,014,091,711.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,621,893,530.00	2,003,243,982.28



**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	1,127,838,786.40	1,386,569,991.01
210102	Нэмэгдэл	397,544,971.60	545,949,349.27
210104	Урамшуулал	29,277,547.00	70,724,642.00
210105	Гэрээт ажлын хөлс	67,232,225.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	203,891,174.88	249,775,900.83
210201	Тэтгэврийн даатгал	138,994,468.21	172,033,719.90
210202	Тэтгэмжийн даатгал	16,448,491.91	19,824,982.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,041,893.20	15,580,626.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,185,989.14	3,939,466.99
210205	Эрүүл мэндийн даатгал	32,220,332.42	38,397,104.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	481,304,192.00	546,119,529.41
210301	Гэрэл, цахилгаан	19,729,738.00	28,343,998.35
210302	Түлш, халаалт	372,716,576.00	446,757,381.06
210303	Цэвэр, бохир ус	88,857,878.00	71,018,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	250,000.00
2105	Нормативт зардал	41,387,294.00	90,804,345.00
210502	Хоол, хүнс	41,387,294.00	90,804,345.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	25,999,980.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	25,999,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,215,957.00	17,772,947.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,338,300.00	6,905,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,877,657.00	10,867,647.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,167,606.00	80,125,025.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,554,399.00	58,174,140.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,613,207.00	21,950,885.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,534,559.93	141,087,240.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	251,324,974.00	137,023,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	123,853,514.00	108,487,450.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	127,471,460.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	28,536,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,209,585.93	4,063,690.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,209,585.93	4,063,690.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	120,890,446.19	285,713,148.19
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	56,355,000.00	94,282,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,355,000.00	94,282,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,355,000.00	94,282,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,355,000.00	94,282,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-56,355,000.00	-94,282,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	64,535,446.19	191,430,348.19

005
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 БҮГДЭЛЭГ
 САНАЛ ДҮГНЭЭТ

	(VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	64,535,446.19
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,535,446.19	255,965,794.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,468,610,681.55	2,034,769,644.05	-3,497,040,917.60	6,339,408.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	-3,497,040,917.60	6,339,408.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	4,543,248,916.10	4,543,248,916.10
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	1,046,207,998.50	4,549,588,324.10
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	1,046,207,998.50	4,549,588,324.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	1,046,207,998.50	4,549,588,324.10
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,264,486,249.80	1,264,486,249.80
20	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	2,310,694,248.30	5,814,074,573.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,505,473,000.0	3,245,398,061.2	260,074,938.8	92.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,505,473,000.0	3,245,398,061.2	260,074,938.8	92.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,333,618,900.0	3,108,374,511.2	225,244,388.8	773.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,192,255,500.0	2,003,243,982.3	189,011,517.7	91.4
210101	Үндсэн цалин	1,513,479,700.0	1,386,569,991.0	126,909,709.0	91.6
210102	Нэмэгдэл	593,221,800.0	545,949,349.3	47,272,450.7	92.0
210104	Урамшуулал	85,554,000.0	70,724,642.0	14,829,358.0	82.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	274,032,300.0	249,775,900.8	24,256,399.2	91.1
210201	Тэтгэврийн даатгал	186,342,000.0	172,033,719.9	14,308,280.1	92.3
210202	Тэтгэмжийн даатгал	21,922,600.0	19,824,982.4	2,097,617.6	90.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,538,100.0	15,580,626.8	1,957,473.2	88.8
210204	Ажилгүйдлийн даатгал	4,384,500.0	3,939,467.0	445,033.0	89.8
210205	Эрүүл мэндийн даатгал	43,845,100.0	38,397,104.8	5,447,995.2	87.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	550,233,200.0	546,119,529.4	4,113,670.6	99.3
210301	Гэрэл, цахилгаан	28,108,200.0	28,343,998.4	-235,798.4	100.8
210302	Түлш, халаалт	447,925,000.0	446,757,381.1	1,167,618.9	99.7

**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	74,200,000.0	71,018,150.0	3,181,850.0	95.7
210304	Байрны түрээс	0.0	0.0	0.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,000,000.0	4,000,000.0	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.0	4,000,000.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,000,000.0	25,999,980.0	20.0	100.0
210604	Урсгал засвар	26,000,000.0	25,999,980.0	20.0	100.0
2105	Нормативт зардал	98,644,400.0	90,804,345.0	7,840,055.0	92.1
210502	Хоол, хүнс	98,644,400.0	90,804,345.0	7,840,055.0	92.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,539,200.0	21,522,947.7	16,252.3	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,905,300.0	6,905,300.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,633,900.0	14,617,647.7	16,252.3	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,914,300.0	166,907,826.0	6,474.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,963,400.0	144,956,941.0	6,459.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,950,900.0	21,950,885.0	15.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	171,854,100.0	137,023,550.0	34,830,550.0	79.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	171,854,100.0	137,023,550.0	34,830,550.0	79.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,318,000.0	108,487,450.0	34,830,550.0	75.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,536,100.0	28,536,100.0	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,505,473,000.0	3,436,828,409.4	64,580,900.0	199.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,847,773,600.0	2,847,773,600.0	0.0	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,847,773,600.0	2,847,773,600.0	0.0	100.0
310002	Орон нутгийн төсвөөс санхүүжих	536,183,200.0	532,119,509.4		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	56,985,300.0	56,935,300.0	50,000.0	99.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,905,300.0	1,022,400.0	5,882,900.0	14.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,080,000.0	55,912,900.0	-5,832,900.0	111.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,530,900.0	0.0	64,530,900.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	64,535,446.2	-64,535,446.2	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	255,965,794.4	255,965,794.4	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.0	0.0	0.0	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	118.0	118.0	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	91.0	91.0	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	26.0	26.0	0.0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,256.0	1,256.0	0.0	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,256.0	1,256.0	0.0	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	1,256.0	1,256.0	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	118.0	118.0	0.0	100.0

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЭТ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон "Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилд "Эрүүл чийрэг бие бялдартай, эрдэм мэдлэгийг эрхэмлэсэн, хүн бүрт тэгш, хүртээмжтэй боломж олгосон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хамт олноороо хүмүүнлэг, оюунлаг, чадварлаг иргэнийг төлөвшүүлэх" зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тус сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захиргаа аж ахуй, Нийгмийн ухаан, Байгалийн ухаан, Бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттай 117 орон тоотой, 1256 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1264,486.4 мянган төгрөгөөр буюу 27.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	64,535,4	255,965,8	191,430.40
Авлага	0	-	0)
Бараа материал	295567,8	224768,1	(70799,7)
Үндсэн хөрөнгө	4,189,485.10	5,333,340.7	1,143,855.6
Нийт хөрөнгө	4,549,588.30	5,814,074.60	1,264,486.30
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,549,588.30	5,814,074.60	1,264,486.30
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,549,588.30	5,814,074.60	1,264,486.30

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.



Тайлант онд цалингийн зардал, үдийн цай санхүүжилтээс шалтгаалж, оны эцэст харилцах дансанд 255,965.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 191,340.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Сургуулийн захирлын 2023.06.21-ны өдрийн А/34, 2023.12.20-ны өдрийн А/60 дугаар тушаалаар нийт 70,017.0 мянган төгрөгийн бараа материал акталснаас өмнөх оноос бараа материал буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд авлага, өглөггүй ажилласан байна.

Төсвийн хөрөнгөөр 94,282.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,320,305.7 мянган төгрөг, нийт үндсэн хөрөнгө тайланд онд 1,414,588.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 10 сарын 11-ний өдрийн 16/49 тоот тогтоолоор 76,557.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 1,264,486.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,310,694.2 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 1,264,486.3 мянган төгрөгөөр нэмэгдэн 5,814,074.6 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,940,266.1 мянган төгрөгөөр төлөвлөж, 2022.07.23-ны өдөр аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн саналаас 963,718.0 мянган төгрөгөөр буурч 1,976,548.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийг дээд шатны байгууллагаас 6 удаа тодотгож цалин нэмэгдсэнтэй холбоотой 952,691.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,929,239.8 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 2,929,239.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 2,673,278.6 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 255,965.8 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 536,183.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр санхүүжилтийн 99.3 хувь буюу 532,119.5 мянган



төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 4,063.6 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ..

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	5,853,6	5,853,6	0.00	100
2	80312 Сургалт семинар	2,926,8	2,926,8	0.00	100
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	5,853,6	5,851,6	1,9	100
4	81801 Үдийн цай хөтөлбөр	143,318,0	108,487,4	34,830,5	76
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	146,760,8	132,806,4	13,954,4	90
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	79,260,8	79,260,7	100.00	100
7	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	16,905,0	16,905,0	0.00	100
8	81823 Боловсролын байгууллагын багш	13,170,5	13,166,3	4,2	100
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	2,054,364.1	1,860,150.9	194,213,2	91
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	447,641,3	434,684,5	12,956,8	97
11	81848 Сурах бичгийн түрээс	6,905,3	6,905,3	0.00	100
12	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын төлбөр	6,280,0	6,280,0	0.00	100
13	80112 Нийтлэг үйлчилгээ	576,233,2	572,119,5	4,113,7	99
	ДҮН	3,505,473,0	3,245,398,0	260,075.0	92.3

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор сумн ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 143,318.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 4 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр 4 хүнсний материал нийлүүлэх байгуулагатай гэрээ байгуулан гүйцэтгэлээр 108,487.5 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 98,644.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 4 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр 3 байгуулагатай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 90,804.3 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 77,921.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан



гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Л.Ононхүү, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Янжмаа нар зурж, аж ахуйн нярваар Б.Идэрханд, хүнсний нярваар Г.Нацагюмсүрэн нар ажиллажээ

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын нийт зардлын 2,270,701.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 22,707.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,030.2 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,504,061.9 мянган төгрөгийн 44 гүйлгээ, зарлагын 688,884.2 мянган төгрөгийн 45 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 153,834.2 мянган төгрөгийн 22 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б. Должмаа гүйцэтгэж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгч байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	5,451.9	3	5,451.9	100
Нийт дүн	3	5,451.9	3	5,451.9	100

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2023.05.19-ны өдрийн 85 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 85 дугаар албан бичгээр бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил дутагдал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---

